

*Зам, тээврийн хөгжлийн сайдын
2024 оны 03 сарын 27-ны А/72 тоот
тушаалын 03 дугаар хавсралт*



ИНД - 105

Шүхрийн үйл ажиллагааны дүрэм

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-105 нь ослын шүхрийн буулт болон агаарын хөлгөөс үйлдээгүй шүхрийн буултаас бусад, шүхрийн үйл ажиллагаа, төхөөрөмж болон техник үйлчилгээтэй холбоотой зохицуулалтын шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-105-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-105, түүний нэмэлт өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх

Анхны боловсруулалт

Хоёрдугаар боловсруулалт

Гуравдугаар боловсруулалт

Өөрчлөлт 3.1

Хүчинтэй огноо

2002 оны 09 сарын 12

2010 оны 05 сарын 07

2019 оны 06 сарын 12

2024 оны 03 сарын 27

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	1
105.1. Хамрах хүрээ	1
105.3. Нэр томьёо ба товчлол.....	1
105.5. Шүхрийн буулт үйлдэх этгээд	1
105.7. Аюултай нөхцөл байдал үүсгэх.....	1
105.9. Агаарын хөлгөөс гарах	2
105.11. Шүхэр задлах минимум өндрийн-түвшин	2
105.13. Шүхрийн буулт	2
105.15. Шүхрээр буух талбай.....	2
105.17. Газрын дохио	3
105.19. Хяналттай агаарын зай	3
105.21. Аэродром дээр буулт үйлдэх	3
105.23. Цэргийн үйл ажиллагааны болон хязгаарлалттай бүсэд буулт үйлдэх.....	3
105.25. Үүлнээс зай барих.....	3
105.27. Их өндрийн-түвшнээс буулт үйлдэх.....	3
В Бүлэг - Шүхрийн төхөөрөмж	4
105.51. Шүхэр	4
105.53. Алтиметр	4
105.55. Автомат задлагч төхөөрөмж (АЗТ)	4
105.57. Аюулгүй байдлын хамгаалалтын хэрэгсэл.....	5
С Бүлэг - Шүхрийн техник үйлчилгээ	5
105.101. Шүхрийн техникч.....	5
105.103. НТЧ-ын болон аюулгүй байдлын удирдамж.....	6
105.105. Шүхрийн ажиллагаатай байдал	6
105.107. Модификаци болон засвар.....	6
105.109. Шүхрийн иж бүрдлийг шалгах	6
105.111. Шүхрийн бүртгэл хөтлөх.....	7

А Бүлэг - Ерөнхий зүйл

105.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) дараахаас бусад шүхрийн үйл ажиллагааны:
 - (i) ослын шүхрийн буулт;
 - (ii) агаарын хөлгөөс үйлдээгүй шүхрийн буулт;
- (2) шүхрийн төхөөрөмжийн;
- (3) шүхрийн техник үйлчилгээний.

105.3. Нэр томьёо ба товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.

Энэ Дүрэмд үнэмлэх гэж Даргын шилжүүлсэн эрх эзэмшигчийн олгосон шүхэрчний, эсхүл шүхрийн техникчийн үнэмлэхийг ойлгоно.

105.5. Шүхрийн буулт үйлдэх этгээд

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, шүхрийн буулт үйлдэх этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) шүхэрчний үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) тухайн шүхэрчний үнэмлэх болон зэрэглэлийн эрх, хязгаарлалтыг мөрдөх;
- (3) шүхрийн байгууллагын Ерөнхий зааварт багтсан үйл ажиллагааны стандарт болон журмыг мөрдөх.

(b) Хэрэв сурагч-шүхэрчин нь шүхрийн байгууллагаас олгосон Сургагчийн зэрэглэл эзэмшдэг Сургагчийн хяналтад байгаа бол энэ зүйлийн (a)-г мөрдөхийг шаардахгүй.

(c) Хэрэв тандем зорчигч нь дараах тандем-мастерын хяналтад байгаа бол энэ зүйлийн (a)-г мөрдөхийг шаардахгүй:

- (1) шүхрийн байгууллагаас олгосон тандем-мастерын зэрэглэл эзэмшдэг;
- (2) 18 нас хүрсэн;
- (3) ИНД-67-гийн дагуу Даргын олгосон 2-р ангиллын хүчинтэй эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшдэг.

105.7. Аюултай нөхцөл байдал үүсгэх

Шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь хэрэгцээ шаардлагагүйгээр дараах этгээдэд аюултай нөхцөл байдал үүсгэхгүй байх үүрэгтэй:

- (1) тухайн шүхэр хаях агаарын хөлөг, эсхүл бүхээгт байгаа хүмүүст; эсхүл
- (2) бусад шүхэрчид, эсхүл бусад нислэгийн хөдөлгөөнд; эсхүл
- (3) газарт байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд.

105.9. Агаарын хөлгөөс гарах

Дараах этгээд зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аливаа этгээд нь шүхрийн буулт үйлдэхээр агаарын хөлгөөс гарч болохгүй:

- (1) тухайн хөлгийн дарга; эсхүл
- (2) тухайн зорилгоор хөлгийн даргын томилсон этгээд.

105.11. Шүхэр задлах минимум өндрийн-түвшин

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь 600 м-ээс (2000 ft) доошгүй өндөрт үндсэн шүхрээ задална.

(b) Сурагч-шүхэрчин нь 900 м-ээс (3000 ft) доошгүй өндөрт үндсэн шүхрээ задална.

(c) Тандем-мастер нь 1500 м-ээс (5000 ft) доошгүй өндөрт үндсэн шүхрээ задална.

105.13. Шүхрийн буулт

Дараахаас бусад талбайд аливаа этгээд нь шүхрийн буулт үйлдэхгүй байх үүрэгтэй:

- (1) ИНД-71-ийн дагуу C, эсхүл D ангиллын хяналттай агаарын зайд; эсхүл
- (2) шүхрийн байгууллагаас хүчинтэй нислэгийн зурагт заасан, эсхүл тухайн шүхрийн ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг AIP-ын Нэмэлт, эсхүл NOTAM хэлбэрээр зарлан мэдэгдсэнийг үндэслэн зөвшөөрсөн бүсэд.

105.15. Шүхрээр буух талбай

(a) Шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) шүхрийн байгууллагын тогтоосон шүхрээр буух талбайд буух; эсхүл
- (2) Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа тандем-шүхрийн үйл ажиллагааны хувьд, гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан, Даргын хүлээн зөвшөөрсөн шүхрээр буух талбайд буух.

(b) Шүхрээр буух талбайг дараах талбайгаас тусад нь тогтоосон аэродромд шүхэр болон агаарын хөлгийн хөдөлгөөнийг зэрэг үйлдэж болно:

- (1) ашиглаж байгаа хөдөлгөөнт бүсийн хэсгээс;
- (2) ашиглаж байгаа ХБЗ-аас;
- (3) ашиглаж байгаа явгалах замаас;
- (4) ашиглаж байгаа хэлипорт, ХБЗ-ны ойртолтын болон нисэн гарах бүсээс.

(c) Шүхрээр буух усан талбайд шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь дараах нөхцөлийг бататгах үүрэгтэй:

- (1) шүхрээр буух талбай нь тодорхой тогтоосон периметртэй байх;
- (2) бүх шүхэрчдийг татан гаргахад шаардлагатай арга хэмжээ авсан байх.

105.17. Газрын дохио

Хэрэв шүхрийн буулт үйлдэж байгааг газрын дохио ашиглан үзүүлж байгаа бол газрын дохио нь салхи руу чиглэсэн конус болон цагаан өнгийн цагиргаас бүрдэнэ.

105.19. Хяналттай агаарын зай

(a) Орон нутгийн шүхрийн үйл ажиллагаа эрхлэгч болон тухайн агаарын зайг хариуцсан Нислэгийн хөдөлгөөний удирдлагын (НХУ) нэгжийн хооронд гэрээ байгуулснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь хяналттай агаарын зайд шүхрийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх үүрэгтэй.

(b) Дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь хяналттай агаарын зайд шүхрийн буулт үйлдэхгүй, эсхүл түүнд шүхрээр буулт үйлдэн нэвтрэхгүй байх үүрэгтэй:

- (1) тухайн этгээдийг шүхэр хаях агаарын хөлгөөс гарахаас өмнө НХУ-аас шүхрийн буулт үйлдэх зөвшөөрөл олгосон бол;
- (2) тухайн этгээд нь НХУ-ын зөвшөөрлийн дагуу буулт үйлдэх бол.

105.21. Аэродром дээр буулт үйлдэх

Аэродром дээр шүхрийн буулт үйлдэх этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй урьдчилан гэрээ байгуулсан байх;
- (2) хэрэв Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (НХУ) байхгүй бол тухайн аэродром дахь аэродромын нислэгийн хөдөлгөөний хайрцагт үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн хөдөлгөөний замаас зайлсхийх.

105.23. Цэргийн үйл ажиллагааны болон хязгаарлалттай бүсэд буулт үйлдэх

ИНД-71-ийн дагуу тогтоосон цэргийн үйл ажиллагааны бүс, эсхүл хязгаарлалттай бүсэд, тухайн бүсийг хариуцсан эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь шүхрийн буулт үйлдэхгүй байх үүрэгтэй.

105.25. Үүлнээс зай барих

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь үүлнээс зайтай байх үүрэгтэй.

(b) Хэрэв тухайн этгээд нь НХУ-аас тухайн үйлдлийг хийх зөвшөөрөл авсан бол ИНД-71-ийн дагуу C, эсхүл D ангиллын хяналттай агаарын зай гэж тогтоосон агаарын зайд үүл нэвтрэн шүхрийн буулт үйлдэж болно.

105.27. Их өндрийн-түвшнээс буулт үйлдэх

(a) Битүүмжлэлгүй агаарын хөлгөөс шүхрийн буулт үйлдэх этгээд нь:

- (1) 3000 - 3900 м-ийн (10 000 - 13 000 ft) өндрийн-түвшний хооронд 30 минутаас дээш хугацаагаар нисэх бол тухайн агаарын хөлгөөс гарах агшин хүртэл нэмэлт хүчилтөрөгч ашиглана;

(2) 3900 - 6000 м-ийн (13 000 - 20 000 ft) өндрийн-түвшний хооронд, агаарын хөлгөөс гарах агшин хүртэл нэмэлт хүчилтөрөгч ашиглана.

(b) Битүүмжлэлтэй агаарын хөлгөөс шүхрийн буулт үйлдэх этгээд нь 3900 - 6000 м-ийн (13 000 - 20 000 ft) өндрийн-түвшний хооронд, даралт бууруулж эхлэх агшнаас, агаарын хөлгөөс гарах агшин хүртэлх бүх хугацаанд нэмэлт хүчилтөрөгч ашиглана.

(c) 3900 м-ээс (13 000 ft) дээших өндрийн-түвшнээс шүхрийн буулт үйлдэх этгээд нь шүхрийн байгууллагын зохион байгуулсан, их өндрийн-түвшнээс буулт үйлдэх сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байна.

(d) 6000 м-ээс (20 000 ft) дээших өндрийн-түвшнээс шүхрийн буулт үйлдэх этгээд нь даралтыг буулгаж эхлэх агшнаас өмнө, эсхүл агаарын хөлөгт суурилуулсан нэмэлт хүчилтөрөгчийн системээс хэрэглээг салгаснаас эхлэн 3900 м-ээс (13 000 ft) доош өндрийн-түвшин хүртэл өндөр алдах үед хувийн нэмэлт хүчилтөрөгч ашиглана.

В Бүлэг - Шүхрийн төхөөрөмж

105.51. Шүхэр

(a) Шүхрийн буулт үйлдэх этгээд, эсхүл тандем хос нь шүхрийн байгууллагын техникийн стандартыг хангасан үндсэн шүхрээр тоноглогдсон байна.

(b) Шүхрийн буулт үйлдэх этгээд, эсхүл тандем хос нь дараах нөөц шүхрийн иж бүрдлээр тоноглогдсон байна:

- (1) шүхрийн байгууллагын техникийн стандартыг хангасан;
- (2) шүхрийн техникч өмнөх 7 сарын дотор шүхрийн байгууллагын техникийн стандартын дагуу үзлэг шалгалт хийн, дахин баглаж, нислэгт тэнцэхээр гэрчилгээжүүлсэн.

(c) Тандем шүхрийн буулт үйлдэх тандем зорчигч дараах бэхэлгээ, тоноглолтой байна:

- (1) шүхрийн байгууллагын техникийн стандартыг хангасан;
- (2) тандем-мастерын бэхэлгээ тоноглолд таарч, гүйцэд зөв түгжигдсэн.

105.53. Алтиметр

10 секундээс дээш чөлөөт-уналтаар буулт үйлдэх этгээд, эсхүл тандем хос нь:

- (1) шүхрийн буултад ашиглахад тохиромжтой төрлийн, ажиллагаатай алтиметрээр тоноглогдсон байна;
- (2) шөнө гэрэлтдэг алтиметрээр тоноглогдсон байна;
- (3) хөөрөхийн өмнө, алтиметрийг шүхрээр буух талбайд тэглэж тохируулна.

105.55. Автомат задлагч төхөөрөмж (АЗТ)

Шүхрийн буулт үйлдэх сурагч-шүхэрчин, эсхүл тандем хос нь дараах АЗТ-тэй нөөц шүхрээр тоноглогдсон байна:

- (1) 105.111-д шаардсан шүхрийн иж бүрдлийн эвхэлтийн бүртгэлд, тухайн шүхрийн иж бүрдэлтэй тохирч байгааг шүхрийн техникч бататгасан;
- (2) үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу техник үйлчилгээ болон тохиргоо хийсэн;
- (3) нөөц шүхрийг шүхрээр буух талбайгаас дээш, дараах минимум өндөрт задлахаар тохируулсан:
 - (i) сурагч-шүхэрчний буултын хувьд, 300 м (1000 ft); эсхүл
 - (ii) тандем-шүхрийн буултын хувьд, 600 м (2000 ft); эсхүл
 - (iii) тухайн хэрэглээний категорийн хувьд, урьдчилан тогтоосон өндөр (АЗТ-ийн үйлдвэрлэгчээс тухайн АЗТ-д тохируулсан болон шүхрээр буух талбайд тэглэсэн);
- (4) шүхрийн техникч үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу үзлэг шалгалт хийсэн.

105.57. Аюулгүй байдлын хамгаалалтын хэрэгсэл

- (a) Усанд шүхрийн буулт үйлдэхээр зорьж байгаа этгээд нь толгойгоо усны гадаргуу дээр ил байлгахад тохиромжтой хөвөх хэрэгслийг өмссөн байна.
- (b) Усны аюултай орчноос 1,8 км (1 nm) хүртэлх зайд шүхрийн буулт үйлдэхээр зорьж байгаа сурагч-шүхэрчин нь толгойгоо усны гадаргуу дээр ил байлгахад тохиромжтой хөвөх хэрэгслийг өмссөн байна.
- (c) Шүхрийн буулт үйлдэх сурагч-шүхэрчин нь шүхрийн байгууллагаас маягийг нь зөвшөөрсөн хамгаалалтын хатуу дуулган малгай өмссөн байна.
- (d) Шүхрийн буулт үйлдэх тандем хос нь шүхрийн байгууллагаас зөвшөөрсөн хамгаалалтын малгай өмссөн байна.

С Бүлэг - Шүхрийн техник үйлчилгээ

105.101. Шүхрийн техникч

Шүхрийн техникч нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) 18 нас хүрсэн байх;
- (2) шүхрийн байгууллагаас олгосон шүхрийн техникчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (3) тухайн шүхрийн техникчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтыг мөрдөх;
- (4) тухайн шүхрийн байгууллагын үйл ажиллагааны стандарт болон журмыг мөрдөх; эсхүл
- (5) Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тандем-шүхрийн хувьд, шүхрийн техникч нь ИНД-115.61-ийн дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн хүрээнд тухайн тандем-шүхрийн техник үйлчилгээг хийх.

105.103. НТЧ-ын болон аюулгүй байдлын удирдамж

Шүхрийн иж бүрдэл нь дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь шүхрийн буулт үйлдэхгүй байх үүрэгтэй:

- (1) ИНД-39-ийн дагуу болон Даргын гаргасан хамааралтай НТЧ-ын удирдамж;
- (2) шүхрийн байгууллагаас гаргасан хамааралтай аюулгүй байдлын удирдамж;
- (3) дараахаас бусад тохиолдолд, үйлдвэрлэгчийн гаргасан хамааралтай, заавал хэрэгжүүлэх модификаци, эсхүл зааварчилгаа:
 - (i) тухайн модификаци, эсхүл зааварчилгааг шүхрийн байгууллагаас гаргасан аюулгүй байдлын удирдамжид заасан байх; эсхүл
 - (ii) тухайн модификаци, эсхүл зааварчилгаанд оруулсан засварыг шүхрийн байгууллага зөвшөөрсөн байх.

105.105. Шүхрийн ажиллагаатай байдал

(a) Шүхрийн иж бүрдлийг ажиллагаагүй, эсхүл нислэгт тэнцэхгүй болохыг тогтоосон этгээд нь тухайн иж бүрдэл ажиллагаагүй гэдгийг тодорхой тэмдэглэж, бататгах үүрэгтэй.

(b) Аливаа этгээд нь, ажиллагаагүй гэж тэмдэглэсэн шүхрийн иж бүрдлийг дахин үзлэг шалгалт хийж, ажиллагаатай байдлыг сэргээх болон нислэгт тэнцэх байдалд оруулах хүртэл ашиглалтад шилжүүлэхгүй.

105.107. Модификаци болон засвар

Шүхрийн иж бүрдлийн НТЧ-т нөлөөлж болох хэлбэрээр өөрчлөлт, эсхүл засвар хийсэн, эсхүл бэхэлгээ тоноглол болон сав, баглааны системийг шүхрийн техникч шүхрийн байгууллагаас баталсан техникийн стандартын дагуу дахин үзлэг шалгалт болон үнэлгээ хийж гүйцэтгэснээс бусад тохиолдолд, аливаа этгээд тухайн шүхрийг ашиглахгүй.

105.109. Шүхрийн иж бүрдлийг шалгах

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд шүхрийн иж бүрдлийн ажиллагаатай байдлыг дараах хэлбэрээр шалгаагүй бол шүхрийн буулт үйлдэхгүй:

- (1) шүхрийн иж бүрдлийн эвхэлтийн бүртгэлийн ишлэлийг шалгах;
- (2) өргөн хүрээтэй гадна үзлэг хийх;
- (3) бүх төхөөрөмжийг зохих ёсоор ажиллахаар тохируулсныг шалгах;
- (4) шүхрийн иж бүрдлийн зохистой ажиллагаанд нөлөөлөх эд зүйл авч яваагүй болохыг бататгах.

(b) Сурагч-шүхэрчний хувьд, шүхрийн байгууллагаас тухайн сурагчийн буултад шууд хяналт тавихаар зөвшөөрөгдсөн этгээд нь энэ зүйлийн (a)-д заасны дагуу тухайн сурагчийн хэрэглэж байгаа төхөөрөмжид үзлэг хийнэ.

(c) Тандем зорчигчийн хувьд, тандем-мастер нь энэ зүйлийн (a)-д заасны дагуу тухайн тандем зорчигчийн хэрэглэж байгаа төхөөрөмжид үзлэг хийнэ.

105.111. Шүхрийн бүртгэл хөтлөх

- (a) Ослын, эсхүл нөөц шүхрийн иж бүрдлийн өмчлөгч нь иж бүрдлийн ажиллагаатай байдлын тухайн үеийн төлөв байдлыг тэмдэглэсэн иж бүрдлийн эвхэлтийн бүртгэлийн карт хөтлөх үүрэгтэй. Эвхэлтийн бүртгэл нь тухайн шүхрийн иж бүрдэлтэй байнга хамт байх ёстой.
- (b) Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэггүй сурагч-шүхэрчний шүхрийн иж бүрдэл, эсхүл тандем-шүхрийн иж бүрдлийн өмчлөгч нь шүхрийн байгууллагын зөвшөөрсөн форматаар тухайн иж бүрдлийн байнгын бүртгэлийг хөтлөх үүрэгтэй.
- (c) Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа тандем-шүхрийн иж бүрдлийн өмчлөгч нь иж бүрдлийн бүртгэлийг ИНД-115.67-гийн шаардлагын дагуу хөтлөх үүрэгтэй.
- (d) Ослын, эсхүл нөөц шүхрийн иж бүрдлийн өмчлөгч, эсхүл ашиглагч болон энэ зүйлийн (b)-д дурдсан шүхрийн иж бүрдлийн өмчлөгч нь Дарга шаардсан үед, эсхүл тухайн шүхрийн байгууллагын журамд заасны дагуу бүртгэлийг шалгуулахад бэлэн байлгах үүрэгтэй.

--oOo--